



“Эм Ай Си Си” ҮЦК ХХК
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Явуухулангийн цэцэрлэг,
Жи Жи тауэр, 7 давхарт
Утас: +976 7011-2023
И-мэйл: info@micc.mn, Вэб: www.micc.mn

Огноо: 2021/11/24

№ 21/118

Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ-Д

*Богд Банк ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн
арилжааны хуваарилалтын төлөвлөгөө хүргүүлэх тухай*

УИХ-аас 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсны дагуу банкны системд нөлөө бүхий банкууд нь 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болох, бусад банкуудад нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани байх сонголтыг нээлттэй үлдээсний дагуу “Богд банк” ХХК (“Богд Банк”) -аас дээрх хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд нийтэд үнэт цаасаа санал болгон гаргаж, олон нийтийн нээлттэй хувьцаат компани болсон анхны банк болж байна.

“Богд банк” ХХК нь “Эм Ай Си Си ҮЦК” ХХК (Регистрийн дугаар 5011558) -тай “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г 2021 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр байгуулж, хамтран ажиллаж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өнөөдрийн ээлжит хуралдаанаар “Богд банк” ХХК-ийн 62,500,000 /жаран хоёр сая таван зуун мянга/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, нэг бүрийн үнийг 2,540 /хоёр мянга таван зуун дөч/ төгрөгөөр 12,500,000 /арван хоёр сая таван зуун мянга/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон худалдахыг 508 тоот тогтоолоор зөвшөөрсний дагуу Монголын хөрөнгийн биржээр (“МХБ”) дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахад бэлэн болоод байна.

Нийт гаргаж буй хувьцааны 8,750,000 /найман сая долоон зуун тавин мянга/ ширхэгийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдэх 30 хувь буюу 3,750,000 /гурван сая долоон зуун тавин мянга/ ширхэг хувьцааг олон нийтэд тус тус хуваарилах бөгөөд Богд Банкны анхдагч зах зээлийн арилжааг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр эхлүүлж 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийг дуустал өглөөний 10 цаг 00 минутаас 16 цаг 00 минутын хооронд Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 10-р зүйлд зааснаар ТОГТООСОН ҮНЭЭР САНАЛ БОЛГОХ АРИЛЖАА-г дараах төлөвлөгөөгөөр зохион байгуулна. Үүнд:

1. Нийт 31,750,000,000 /гучин нэгэн тэрбум долоон зуун тавин сая/ төгрөгийн үнийн дүн бүхий 12,500,000 /арван хоёр сая таван зуун мянга/ ширхэг хувьцааны 70 хувь буюу 22,225,000,000 /хорин хоёр тэрбум хоёр зуун хорин таван сая/ төгрөгийн 8,750,000 /найман сая долоон зуун тавин мянга/ ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилах бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдыг 4 багц болгон хөрөнгө оруулагч тус бүрд хуваарилагдах үнэт цаасны тоо ширхэг, холбогдох мэдээллийг анхдагч зах зээлийн арилжааны явцад МХБиржид хүргүүлнэ.
2. МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт тодорхойлсноор стратегийн хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд

- давуу талыг бий болгож хувь тэнцүүлэх аргыг үл харгалзан худалдан авах захиалгыг цаг хугацааны дарааллаар арилжааны програмд оруулна.
3. Хэрэв стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилах үнийн дүнгээс захиалга илүү гарсан тохиолдолд илүүдэл захиалгыг олон нийтэд санал болгох 30%-д оруулж тооцно.
 4. Стратегийн хөрөнгө оруулагч гэж 500,000,000 /таван зуун сая/ төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хувьцааг 6 болон түүнээс дээш сараар тусгаарлуулах нөхцөлтэй дараах 4 багц хөрөнгө оруулагчдыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
 - 4.1 "Богд банк" ХХК, "Эм Ай Си Си ҮЦК" ХХК-тай хувьцаа худалдан авахаар урьдчилсан захиалгын гэрээ байгуулсан харилцагчид /Багц 1, 2; хавсралт 1,2/,
 - 4.2 Үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу хувьцаагаа 6 сараар тусгаарлуулахаар зөвшөөрсөн ажилтнууд /Багц 3; хавсралт 3/,
 - 4.3 Андеррайтер "Эм Ай Си Си ҮЦК" ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд ажиллаж буй хамтрагч үнэт цаасны компаниудын хөрөнгө оруулагчдыг /Багц 4; хавсралт 4/ тус тус давуу эрхээр бүрэн биелүүлэх юм.
 5. Нийт 31,750,000,000 /гучин нэгэн тэрбум долоон зуун тавин сая/ төгрөгийн үнийн дүн бүхий 12,500,000 /арван хоёр сая таван зуун мянга/ ширхэг хувьцаанаас стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилагдаагүй үлдсэн 9,525,000,000 /есөн тэрбум таван зуун хорин таван сая/ төгрөгийн үнийн дүн бүхий 3,750,000 /гурван сая долоон зуун тавин мянга/ ширхэг үнэт цаасыг олон нийтэд нээлттэйгээр хуваарилна.
 6. Жижиглэнгийн буюу олон нийтээс хувьцаа худалдан авах захиалгын үнийн дүн, тоо ширхэг нь дээр дурьдсан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд нэгж хөрөнгө оруулагчийн 100 /нэг зуу/ ширхэг хувьцаанаас давсан үнэт цаасны захиалгуудыг хувь тэнцүүлэх аргыг ашиглан жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад үнэт цаасны хуваарилалт хийнэ.

ХҮНДЭТГЭСЭН



Х.МӨНХЗУЛ